



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 26 өдөр

Дугаар А/406

Мөрөн сум

Тусгай зөвшөөрлийг түр хугацаагаар  
сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 1.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.7, 40 дүгээр зүйлийн 40.7, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Засгийн газрын тогтоолоор батлагдах журам, хамтарсан тушаалаар батлагдах норм норматив батлагдаагүй байгаатай холбогдуулан иргэдийн өргөдөл, хүсэлтийг үндэслэн согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түр хугацаагаар сунгах жагсаалтыг хавсралтаар баталж, сунгасугай.

2. Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа (А.Алтанцоож), холбогдох сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдөж, аймгийн Засаг даргын 2016 оны А/10, 2016 оны А/194 дүгээр захирамжаар батлагдсан цагийн хязгаарт нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулахыг согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (М.Алтаншагай)-д даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 07  
дугаар сарын 26-ны өдрийн А/...  
дугаар захирамжийн хавсралт

СОГТУУРУУЛАХ УНДАА ХУДАЛДАХ, ТҮГЭЭР ҮЙЛЧЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУГАЦААГ ТҮР СУНГАСАН ЖАГСААЛТ

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн		Нэр, байршил	Тусгай зөвшөөрлийн төрөл
	Оршин суугаа хаяг	Иргэн, аж ахуй нэгжийн нэр		
1	Түнэл сум 6-р баг	Доржрэгзэд Отгонбаяр РМ67071304	"Олонбулаг" Хүнсний дэлгүүр Түнэл сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
2	Цагаан-Уул сум 6-р баг	Даваасамбуу Мөнхбат РД71032118	"Оргил" Хүнсний дэлгүүр Цагаан-Уул сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах
3	Галт сум 5-р баг	Базаррагчаа Тунгалаг РД76032201	"Баянзүрх" Хүнсний дэлгүүр Галт сумын төвд	Спиртийн өндөр агууламжтай согтууруулах ундаа худалдах

---oOo---